


1. БАЯНГОЛЫН ДЭНЖ УУРХАЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Уурхайн үйл ажиллагаа явагдаж буй газрын засаг захиргааны харьяалал

Баянголын дэнжийн орд нь Улаанбаатар хотоос баруун хойш 230 км, Төв аймгийн Заамар сумаас баруун хойш 35 км-т Туул голын баруун гар талын эрэг дагуу байрлана.

Зураг 1. Уурхайн байршил



Хүснэгт 1. Заамар өгөөмөр хайрхан ХХК-ийн мэдээлэл

Аж ахуйн нэгжийн нэр	Аж ахуйн нэгжийн регистрийн дугаар	Үйл ажиллагааны чиглэл	Заамар өгөөмөр хайрхан ХХК-ийн хаяг, байршил
Заамар өгөөмөр хайрхан ХХК	3863689	Төв аймгийн Заамар сумын нутагт байрлах Баянголын дэнж алтны шороон орд олборлох төсөл	Төв аймаг Заамар 3-р баг Хайлааст өгөөмөр -2 5

Хүснэгт 2. Заамар өгөөмөр хайрхан ХХК-ийн холбогдох албан тушаалтнуудын мэдээлэл

№	Нэр	Албан тушаал	Утасны дугаар
1	Ч.Уламбаяр	Заамар өгөөмөр хайрхан ХХК Ерөнхий захирал	99990795
2	А.Дүүрэнбаяр	Заамар өгөөмөр хайрхан ХХК Ерөнхий геологич	99312978
3	С.Жамъянсүрэн	Уурхайн дарга	99086509

1.2. Түүхэн товчоон

Төв аймгийн Заамар сумын нутагт “Баянголын дэнж” нэртэй газарт орших 108.6 гектар талбай бүхий уурхайн талбайд хуульд заасан нөхцөл, шаардлагын дагуу ашигт малтмал ашиглахыг зөвшөөрч улсын бүртгэлийн АМГТХЭГ-ийн даргын тушаалаар 30 жилийн хугацаатай олгосон байдаг. “Баянголын дэнж” нэртэй 005А дугаар бүхий тусгай зөвшөөрлийг “Алтандорнод монгол” ХХК-д олгож байсан бөгөөд 2023 оны 10-р сарын 27-ны өдөр тус тусгай зөвшөөрлийг “Заамар өгөөмөр хайрхан” ХХК шилжүүлэн авсан байна.

1.3. Ордын геологийн тогтоц

Судалгааны талбайд дунд кембрий-доод ордовикийн тунамал-хувирмал, дунд-дээд триасын ба доод цэрдийн тунамал хурдас, дөрөвдөгчийн сэвсгэр хурдас болон лландовери (доод силур) силур, дунд девоны гүний чулуулаг үүсч тархсан.

1.4. Баянголын дэнж уурхайн техник эдийн засгийн үндэслэл

Ашигт малтмал газрын тосны газрын Эрдэс баялагийн мэргэжлийн зөвлөлөөр 2025 оны 04 дугаар сарын 17-ны өдөр “Топ молор майнинг” ХХК-ийн боловсруулсан Төв аймгийн Заамар сумын нутагт орших Баянголын дэнж алтны шороон ордыг ил аргаар ашиглах уурхайн, баяжуулах үйлдвэрийн Техник-эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ)-ийг хэлэлцэж, № Т/25-04-02 тоот дүгнэлтийг гаргасан. Энэ дүгнэлтэд үндэслэн Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн Т/48 тоот тушаалаар Баянголын дэнж шороон ордыг ашиглах уурхайн, баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ-г хүлээж авсан.


Хүснэгт 3. Тусгай зөвшөөрлийн хүрэн дэх үлдэгдэл геологийн нөөц

Блокын дугаар, Нөөцийн зэрэг	Блокын талбай	Хөрсний зузаан	Элсний зузаан	Хөрсний эзлэхүүн	Элсний эзлэхүүн	Дундаж агуулга	Металлын нөөц (Шлхх/	Химн нөөц
Х.нэгж	мян.м ²	м	м	мян.м ³	мян.м ³	мг/м ³	кг	кг
Зүүн хойд хэсэг ХШ (714-716)								
C-1	0.43	36.8	1.2	15.7	0.5	1,096	0.56	0.49
B-2	1.82	37.6	1.1	68.3	1.9	1,231	2.38	2.10
B-3	1.92	36.8	1.1	70.8	2.1	1,457	2.99	2.63
B-4	0.93	34.8	1.2	32.5	1.1	1,121	1.25	1.10
C-5	0.79	35.0	1.2	27.8	1.0	832	0.79	0.70
Нийт В	4.67	36.7	1.1	171.5	5.1	1,295	6.62	5.83
Нийт С	1.22	35.6	1.2	43.5	1.5	921	1.35	1.19
Нийт В+С	5.89	36.5	1.1	215.0	6.6	1,212	7.97	7.02
Баруун өмнөд хэсэг ХШ (724-2-728-1)								
C-6	0.85	16.2	1.2	13.8	1.0	508	0.52	0.46
B-7	2.66	16.4	1.0	43.6	2.8	482	1.33	1.17
B-8	1.81	16.5	1.1	29.9	2.0	610	1.22	1.07
B-9	8.55	20.7	1.5	177.0	12.4	653	8.10	7.12
B-10	4.84	21.2	1.4	102.8	6.9	622	4.28	3.76
C-11	2.20	21.5	1.4	47.3	3.2	621	1.97	1.73
Нийт В	17.86	19.8	1.3	353.3	24.0	621	14.93	13.12
Нийт С	3.05	20.0	1.4	61.1	4.2	595	2.49	2.19
Нийт В+С	20.91	19.8	1.3	414.4	28.2	617	17.42	15.31
Зүүн өмнөд хэсэг ХШ (726а-728а)								
C-12	0.44	31.2	0.8	13.8	0.4	1,554	0.55	0.48
B-13	2.47	37.8	2.2	93.2	5.4	663	3.60	3.16
B-14	4.77	39.4	2.2	188.0	10.4	727	7.52	6.61
C-15	2.68	38.7	1.7	103.8	4.4	972	4.34	3.81
B-16	2.76	48.7	1.3	134.6	3.6	793	2.93	2.58
C-17	1.55	51.0	1.2	78.9	1.9	738	1.37	1.20
Нийт В	10.00	41.6	1.9	415.7	19.4	725	14.05	12.35
Нийт С	4.67	42.1	1.4	196.5	6.6	942	6.26	5.49
Нийт В+С	14.67	41.7	1.8	612.2	26.0	781	20.31	17.84
Ордын хэмжээнд								
БҮГД В	32.54	28.9	1.5	940.5	48.5	733.75	35.60	31.30
БҮГД С	8.94	33.7	1.4	301.1	12.3	821.46	10.10	8.87
БҮГД В+С	41.48	29.9	1.5	1,241.6	60.8	751.49	45.70	40.17

1.5.Баянголын дэнж ил уурхайн мэдээлэл

Геологийн нөөцийн хайгуулын ажлаар ил уурхайн хүрэн дэх ашиглах нөөцөөр 73,41 мян.м³ элс, 28,91 кг алтыг /хим.цэв/ хаягдалгүйгээр бүрэн олборлоно. Үйлдвэрлэлийн нөөцийн тооцоогоор төсөл хэрэгжих хугацаанд ордоос нийт үржил шимт хөрс 4.95 мян.м³, үндсэн хөрс 1423,3 мян.м³ тус тус хуулах бол дунджаар 468,9 мг/м³ агуулга бүхий 73,41 мян.м³ элс /элсэн дэх металлын химийн цэврээр 28,91 кг олборлоно.

Зураг 2. Алт агуулсан элсийг угаан баяжуулах технологийн схем



1.6. Уурхайн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

Хамрах хүрээ: Заамар өгөөмөр хайрхан ХХК-ийн Баянголын дэнж уурхайн MV-00005 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд явагдаж байгаа үндсэн олборлолтын үйл ажиллагааны БОННУ-г холбогдох хууль, журмын дагуу БОАЖЯ-ны 2024 оны 01-р сарын 16-ны өдрийн 12/239 тоот байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлт, 2024 оны 09-р сарын 19-ны өдрийн 05/4395 дугаартай Ерөөнхий үнэлгээний сунгалт гарсны дагуу энэхүү алтны шороон ордын байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг боловсруулж 2025 онд батлуулсан тус тайланд тусгагдсанаар нийт хөндөгдөх талбай 29,4 га талбай олборлолтод өртөгдөж 2026 оноос нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн. Бид бүхэн 2025 онд тус хөндөгдөх талбайгаас 5га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж 0,6 га талбайд биологийн нөхөн сэргээлтийг урьдчилан хийхээр төлөвлөсөн. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээ, нөхөн сэргээлтийн ажлын зардалд нийт гучин зургаан сая хорин гурван мянган төгрөг (3602300₮) төсөвлөсөн байна. нийт барьцаа төлбөрт 18,011,500₮ төгрөг байршуулж холбогдох баримтыг хавсаргав.

Үүн дээр дүйцүүлэн хамгаалах болон нөхөн сэргээлтийн зардлыг урьдчилан тооцох боломжгүй байна. (*Хүснэгт 4*).

№	Ажлын нэр	Зардал /мян.төг/
1	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө	2900.0
2	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	3320.0
3	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1663.0
4	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	2600.0
5	Нөхөн сэргээлт, хаалтын зардал	16940.0
6	Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөний зардал	5000.0
7	Оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх	1600.0
8	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	-
9	Тэрбум мод үндэсний хөдөлгөөн	2000
Нийт зардал		36,023,000₮

2. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Зорилго, зорилт: Баянголын дэнж уурхайн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа 2025 онд “Эко ногоон баялаг” ХХК-ийн боловсруулсан Баянголын дэнж алтны шороон ордоос олборлох, боловсруулах төслийн Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний нэмэлт тодотгол тайлангаар тодорхойлогдсон төсөл хэрэгжүүлэгчийн хүлээх үүрэг амлалтаас гадна Монгол Улсын Байгаль орчны багц хууль, холбогдох дүрэм журам, стандартуудын шаардлагуудыг мөрдлөг болгон боловсруулсан бөгөөд энэ төлөвлөгөөнд тусгагдсан үүрэг даалгавруудыг биелүүлэхийг гол зорилго болгосон. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний гол зорилго нь

төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах хэмжээг төлөвлөхөд оршино.

3. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

БОННУ-ний тайланд төслийн цар хүрээнд бий болох сөрөг нөлөөллийн эрчим нь багаас дунд түвшинд хэлбэлзэх бөгөөд сүйрлийн хэмжээнд хүрэх ноцтой сөрөг нөлөө үзүүлэхгүй. Энэ нь төсөл хэрэгжүүлэх нутгийн байгаль, газарзүйн байршил, байгалийн нөөцийн нөхөн сэргэх чадавхтай холбоотой байх тул сөрөг нөлөөллийг бууруулах, улмаар арилгах боломжтой байна.

Сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.

Хүснэгт 5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Нөлөөллүүд	Нөлөөллийн эх үүсвэрүүд	Бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Нэгжийн зардал	Тоо хэмжээ	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжилтэд тавигдах шалгуур, мөрдөх стандартууд
АГААРЫН ЧАНАР								
Ил уурхайгаас үүсэх тоосжилт	Уурхайн үйл ажиллагаанаас	Зам талбайг усалж байх	Уурхайн зам			1700	2025	“Агаарын тухай”, “Агаарын бохирдлын тухай төлбөрийн тухай” хууль MNS 0017-2-3-16:1998 (суурьшлын хэсгүүдэд) MNS 4585:2008 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага. Галын аюулгүй байдлын тухай:
Хорт хийн ялгарал	Тээврийн хэрэгсэл	Хорт хийн хэмжээг багасгахын тулд машин механизмын засвар үйлчилгээг цаг тухайд нь хийж байх	Төсөлд ашиглах машин механизм	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан			2025	
Дуу чимээ шуугиан								
1700								
ГАЗРЫН ГАДАРГА ХЭВЛИЙД								
Газрыг үр ашиггүй, зохисгүй ашигласнаар газрын шим тэжээл буурах	Уурхайн үйл ажиллагаанаас	Төлөвлөгөөнд тусгаагүй газар талбайд нөлөөлөл учруулахгүй байхаар уулын ажлын төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа хянаж явуулах.	Төслийн талбайд	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан			2025	Газрын тухай хууль “Газрын тухай” хууль “Байгаль орчныг хамгаалах ухай” хуул: “Газрын хэвлийн тухай” хууль
500								
ХӨРСӨН БҮРХЭВЧ								
Хөрсний бүтцэд гарсан өөрчлөлт	Хүний буруутай үйл ажиллагаа	Нефтийн бүтээгдэхүүн бүхий хаягдлыг байгаль орчинд халгүйгээр зайлуулах, бохирдсон хөрсийг тухай бүрд нь цэвэрлэж байх	Төслийн талбайд	100	4	400.0	2025	Газрын тухай хууль MNS 5916:2008 “Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрсний хуулалт, хадгалалт” MNS 5917:2008 “Уул уурхайн үйлдвэрийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт” стандартууд
Хөрс хатуу, шингэн хог хаягдлаар бохирдох								
400.0								
ГАДАРГЫН БОЛОН ГАЗАР ДООРХ УС								

Нөлөөллүүд	Нөлөөллийн эх үүсвэрүүд	Бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Нэгжийн зардал	Тоо хэмжээ	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжилтэд тавигдах шалгуур, мөрдөх стандартууд
Усанд орчинд үзүүлэх нөлөөлөл	Унд ахуйн ус бохирдох	Унд, ахуйн хэрэглээний усанд тогтмол шинжилгээ хийлгэж байх	Гүний худаг	Усны дүгнэлтийн дагуу усны гэрээний дагуу			2025	Монгол Улсын стандарт (MNS 4943-2015), Дэлхийн банкны шалгуур үзүүлэлтүүдийг хангасан байх шаардлагатай. Усны тухай хууль, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль “Усан орчны чанарын үзүүлэлт” MNS 4586:1998. ”Газар доорх усыг бохирдлоос хамгаалах” MNS 3342:1982 Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам
		Гүний худагт тоолуур тавьж баталгаажуулах.	гүний худаг	300.0	1	300	2025	
2900.0								
УРГАМЛАН НӨМРӨГ								
Уурхайн үйл ажиллагаанаас	Уурхай, тээвэрлэлт, шорооны ажлын үед ургамал устах, дарагдах, талхлагдах зэргээр хамгийн их нөлөөлөлд өртөх.	Шимт хөрсийг ургамалжуулж түүн доторх ургал эрхтний нөөцийг хамгаалах	Төслийн талбайд	Биологийн нөхөн сэргээлтийн зардалд тооцогдсон			2025	Ургамал хамгааллын тухай” хууль Байгалийн ургамлын тухай” хууль MNS 5918:2008 “Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага”
АМЬТНЫ АЙМАГ								
Уурхайн ойр орчмын газарт нутагладаг ан амьтдын амьдрах орчинд шууд бус байдлаар нөлөөлөх		Орон нутгийн амьтан хамгаалах үйл ажиллагаанд оролцох		Үйл ажиллагааны зардалд тусгагдсан			2025	"Амьтны аймгийн тухай" хууль: 6.1.7 дахь заалт: үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааны явцад амьтан хөнөөгдөхөөс сэргийлэх
Нийт зардал:								

4. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (мян.төг)	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Байгалийн аюул гамшиг								
Байгалийн давтагдашгүй хүчин зүйл болох	Байгалийн аюул гамшгийн үед авах арга хэмжээний талаар мэдээлэл ажилчдад өгөх, урьдчилан сэргийлэх зөвлөмж гаргах		удаа	1	50.0	1250.0	2025	Гамшгаас хамгаалах тухай хууль, 2003-(сүүлийн нэмэлт өөрчлөлт 2012.05.17)
Нийт						250.0		
Галын аюул								
Төслийн үйл ажиллагаанд техникийн зориулалттай шатах, тослох материалын аюулгүй ажиллагааг хангаагүйгээс галын аюул гарах	Гал түймэр гарахаас урьдчилан сэргийлэх, гал түймэр гарсан тохиолдолд түүнийг шуурхай унтраах багаж хэрэгслийн иж бүрдлийг бэлэн байлгах;	Галын аюул эрсдэл	иж бүрэн	10	500	2000.0	2025	MNS 5390:2004, ХААЭА. Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага Галын аюулгүй байдлын тухай хууль, /шинэчилсэн найруулга/ Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль MNS 5566:2005 Гал түймрээс хамгаалах, аж ахуйн нэгж байгууллага, барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм MNS4244-94 Галын аюулгүй байдлын ерөнхий шаардлага
Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны талаар								
Төслийн үе шатанд хүний эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлөх	Уурхайн ажилчдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт семинарыг тогтмол зохион байгуулах, хамруулах	Төслийн талбайд	удаа	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан			2025	MNS 4968:200“ХААЭА. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага” MNS 4995:2000, “ХААЭА. Доргио хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага”
	Болзошгүй осол, хүний амь насанд аюул учруулж болох нөхцөлүүдээс урьдчилан сэргийлэх	Төслийн талбайд	Удаа	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан				

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (мян.төг)	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	Болзошгүй аваар ослын үед яаралтай хэрэглэх анхны тусламжийн багаж хэрэгсэл, эм тариаг бэлэн байлгах	Төслийн талбайд	иж бүрэн	2	35	70.0	2025	MNS 5002:2000, “ХААЭА. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага” MNS ISO 13688:2000, “ХААЭА. Хамгаалалтын хувцас. Ерөнхий шаардлага” MNS 5010:2001, “ХААЭА. Ажлын байран дахь тоосны агуулгыг хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага” MNS 5105:2001, “ХАБ. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ, ерөнхий шаардлага” MNS ILO OSH 1:2003, “ХААЭА-н удирдлагын тогтолцооны талаарх удирдамж” Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
	Ажилтан бүрийг хөдөлмөр хамгаалах хэрэгслээр хангах	Төслийн талбайд	иж бүрэн	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан				
Нийт дүн						3320.0		

5. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хатуу, шингэн хог хаягдал нь хүн ам, үйлдвэрлэлд хэрэгцээт газрын нөөцийг багасгах, хөрс, ус, агаарыг хорт бодис, хүнд металл, нян вирусээр бохирдуулагч гол эх үүсвэр болдог. Хатуу хог хаягдал нь удаан задарч бодисын эргэлтэд аажмаар орох ба задрах хугацаа нь удаан байдаг учраас байгаль орчинд хор хөнөөлтэй. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг 2017 онд батлагдсан Хог хаягдлын тухай хуулийн үзэл баримтлал, зүйл заалтыг үндэслэн боловсруулав.

Хүснэгт 7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (мян.төг)	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан, ялгах, хог хаягдлыг дахин ашиглах	Хог хаягдал ангилан ялгаж хаях зориулалттай хогийн савнуудыг тосгон, захиргаа, цайны газар зэрэг шаардлагатай газруудад тавих	Энгийн хог хаягдлаас үүсэх нөлөөллийн бүс	удаа			2600.0	2025	Хог хаягдлын тухай хууль БОАЖ-ын сайдын А/433 тушаал “Ариун цэврийн тухай” хууль Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай хууль
	Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж байх		Удаа	Уурхайн дотоод төлөвлөлтөөр			2025	
	Энгийн хог хаягдал үүсгэгч нь хог хаягдлын мэдээ тайланг тогтмол, заасан хугацаанд эрх бүхий байгууллагад хүргүүлнэ.		удаа				2025	
Хог хаягдлаас ялгарах үнэр, амархан муудаж ялзрах бусад хүнсний хаягдал зэргээс халдварт өвчин тархах	Үүсэх хог хаягдлын төрөл, кодыг ЗГ-ын 116 тогтоолд заасан хог хаягдлын кодчилсон жагсаалтын дагуу тогтоосон байх	Аюултай хог хаягдал	удаа	Уурхайн дотоод төлөвлөлтөөр			2025	
	Хөрс шатах тослох материалаар бохирдсон тохиолдолд бохирдсон хэсгийг ялган авч саармагжуулах	Төслийн талбай	Иш бүрэн				2025	
Нийт						2600.0		

Ахуйн хог хаягдлыг хог хаягдлыг ангилах, ачих, цуглуулах технологид нийцсэн, галд тэсвэртэй материалаар хийгдсэн, хог хаягдал салхиар тархах, хур тунадасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн ангилан ялгах зориулалтын сав байрлуулж хог хаягдлын цэгийн тохижуулах



Зураг 1. Хог хаягдлын ангилал, зайлуулах арга



Зураг 2. Дахин ашиглах хог хаягдлыг ангилан ялгаж, түр хадгалах савын жишээ


Төсөл хэрэгжүүлэгч нь ангилан ялгасан, дахин ашиглах боломжтой хог хаягдлыг боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлж хамтран ажиллах шаардлагатай. Харин төслийн үйл ажиллагаанаас гарах аюултай хог хаягдлыг БОАЖ сайдын 2018.01.30 өдрийн А/18 дугаар тушаалын 1-р хавсралтын дагуу Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлох тусгай зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан гэрээний дагуу саармагжуулан, устгах.

Уурхайн үйл ажиллагааны явцад ажилчдын ахуйн хэрэглээнээс үүсэх шингэн хог хаягдал гарна. Нэг хүний усны хэрэглээний нормын дагуу хоногт ажлын болоод ахуйн хэрэгцээнд гүний худгаас хангана гэж үзээд 80 литр байна гэжтооцвол 109 хүний усны хэрэгцээнд хоногт нийт 8,720 л ус, жилд 190 хоног нийт 1,656,800 л ус хэрэглэхээр байна. Үүний 70%-ийг ахуйн шингэн хаягдал болно гэж тооцвол хоногт дунджаар 1,159,760 л шингэн хаягдал гарахаар байна. “Заамар өгөөмөр хайрхан” ХХК нь шингэн хаягдлыг байгаль орчинд халгүй арга хэлбэрээр зайлуулах, дахин ашиглах арга хэмжээг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллана.


6. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт “Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төсөл хэрэгжүүлэх явцад байгаль орчинд үүсэж болзошгүй өөрчлөлтийг хянах, шинжлэх объект, байршил, баримтлах стандарт, арга аргачлал, хугацаа, хариуцах этгээд, хяналт шинжилгээний үр дүнг тайлагнах талаар тодорхой тусгана” хэмээн “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах,

хянан батлах, тайлагнах журам”-ын 2.7-д заасан байна. Үүний дагуу бид байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлангийн байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу энэхүү орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг боловсруулсан болно.



Зураг 12. Ил уурхайн үйл ажиллагаагаас үүсэх TSP тоосны жилийн дундаж агууламжийн тархалт, мкг/м³



Зураг 13. Ил уурхайн үйл ажиллагаагаас үүсэх PM10 тоосны 24 цагийн дундаж агууламжийн тархалт, мкг/м³

Хүснэгт 8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

#	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Байршил	Хугацаа ба давтамж	Хяналт шинжилгээ	Нэгж өртөг	Нийт зардал	Баримтлах стандарт ба арга, аргачлал	Дээд доод хязгаар
Агаарын чанар									
Агаарын чанар	Нүүрстөрөгчийн исэл CO	мкгр/м³	Уурхайн ухаш	Жилд 1 удаа	Campbell Scientific. UT 30 автомат цаг уурын станц	24 цагийн хэмжилтийг хийж, цаг агаарын үзүүлэлтийн хамт тооцоход 25.0 мян.төг	500.0 мян.төг	- MNS 3384:1982 Агаар мандал. Хэмжилтийн ерөнхий шаардлага. - MNS:46-21-2007, Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” - MNS 3113:1981 Агаар мандлын бохирдлыг хэмжих аргачлалын ерөнхий шаардлага - MNS 3384-1982 Агаар мандал-Агаарын дээжид шинжилгээ - MNS 5365:2004 Агаарын чанарын ерөнхий асуудлууд.Тоосонцорын ширхгийн хэмжээг тодорхойлох арга.	Дундаж хэмжилтээр
	Азотын исэл (NO₂)		Технологийн зам дагуу хэмжилт хийнэ		Dust Trak				Дундаж хэмжилтээр
	Хүхрийн давхар исэл (SO₂); HCN, O₂		Орион Плюс драггер		Дундаж хэмжилтээр				
	Тоосонцор (PM2.5, PM10)		2238E Mediator Sound level meter		Дундаж хэмжилтээр				
									30 минутын дундаж-500
								24 цагийн дундаж-150 Жилийн дундаж-100	
								24 цагийн дундаж-50 Жилийн дундаж-25	
								24 цагийн дундаж-100 Жилийн дундаж-500	
Хөрсний чанар									
Хөрсний чанар	pH		Шимт хөрсний овоолго	Жилд 1 удаа	Лабораторийн шинжилгээ	Хөрсний механик бүрэлдэхүүн, ялзмаг – 20.0 мян.төг	480.0 мян.төг	- MNS 3985-87 Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр, төрөл - MNS 2305-04 Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам - MNS 5850:2008 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ	
	CaCO₃	%							хэмжилтээр
	ЕС 2.5	dS/m							хэмжилтээр
	Ялзмаг	%							хэмжилтээр
	Элс	% /мл-ээр/							2-0,05
	Тоос	% /мл-ээр/							0,05-0,002
	Шавар	% /мл-ээр/							<0,002
	Cd / кадми	мг/кг							3
	Cu / зэс	мг/кг							100
	As / хүнцэл	мг/кг							0.05
	Cr / хром	мг/кг							150
	Zn / цайр	мг/кг							300
	Co /кобальт	мг/кг							50

#	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Байршил	Хугацаа ба давтамж	Хяналт шинжилгээ	Нэгж өртөг	Нийт зардал	Баримтлах стандарт ба арга, аргачлал	Дээд доод хязгаар
	Ni / никель	мг/кг				– 20.0 мян.төг		● MNS 4814:1999. Атом шингээлтийн Спектрометрээр шинжилгээ хийх	150
	Pb / хар тугалга	мг/кг							100
	Нийт бичил биетийн тоо	1 см ³							100
Усны чанар									
Усны чанар	pH		- Ундны ус	Жилд 1 удаа	Лабораторийн шинжилгээ	Усны ерөнхий химийн шинжилгээ 28.0 мян.төг	683.0 мян.төг	● MNS 900:2005 Ундны ус-Ундны усны хяналт шинжилгээ ● MNS 3935:1986 Ундны ус-Усны шинжилгээнд тавигдах шаардлага ● MNS 3934:1986 Ундны болон үйлдвэрийн ус-Химийн шинжилгээ хийх, дээж авах, хадгалах, зөөвөрлөх ● MNS 5667-10:2001 Усны чанар-Дээж авах 2-р бүлэг. Хаягдал уснаас дээж авах ● MNS 2573:1978 Байгаль орчныг хамгаалах. Усны чанарын үзүүлэлт.	3-7
	эрдэсжилт	мг/л							1000
	хатуулаг	мг-экв/л							7
	SO4 / сульфат	мг/ л							500
	Cl ⁻ / хлорид	мг/ л							3
	Ca / кальци	мг/ л							100
	NH4 / аммони	мг/ л							1,5
	NO2 / нитрит	мг/ л							3
	NO3 / нитрат	мг/ л							50
	Cd / кадми	мг/ л							0,003
	Cu / зэс	мг/ л							2,0
	As / хүнцэл	мг/ л							0,01
	Cr / хром	мг/ л							0,05
	Zn / цайр	мг/ л							5,0
	Co /кобальт	мг/ л							0,1
	Ni / никель	мг/ л							0,02
	Pb / хар тугалга	мг/ л							0,01
	Fe / төмөр	мг/ л							0,3
	Нийт бичил биетийн тоо	100 мл							100
2025 он							1663.0		
Нийт дүн							1663.0		

7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ:

Уул уурхайн үйл ажиллагааны дараа нөхөн сэргээлтийг маш сайн хийсэн ч нөлөөлөл ямар нэг хэлбэрээр үлддэг. Тэрхүү нөлөөллийг бууруулах олон арга байдгийн нэг нь дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагаа юм.

Хүснэгт 9. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Дүйцүүлэн хамгааллын зорилго	Гүйцэтгэх ажил	Ажил гүйцэтгэх төсөв, сая.төг	Эрх зөвшөөрөл	Хэрэгжилтэд хяналт тавих	Хэрэгжүүлэх хугацаа
Бэлчээрийн даацыг сайжруулах чиглэлээр	Орон нутгийн захиргаатай хамтран ажиллаж тохирсон газарт буюу уурхайн эргэн тойрондох 5 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийх	5	Төв аймгийн Заамар сумын ЗДТГ, БО-ны газар хамтран ажиллах	Заамар сумын БОАЖГазар болон ЗДТГазар	2025 он
Нийт		5 сая			

8. НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Нөхөн сэргээх арга хэмжээ. Төсөл хэрэгжих 1 жилд уурхай нь 29.4 га талбай эвдрэлд өртөнө. Уурхайн нөхөн сэргээлтийг. Ашиглалтын хугацаа дуудсаны дараа 2026 онд хийнэ гэж БОННУ дээр тусгагдсан. 2025 онд 5 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийнэ.

Ордын техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг Байгаль орчин, аялал жуулчлал, ногоон хөгжлийн яамны сайдын хамтарсан 2015 оны 03 сарын 30-ны өдрийн А-138 дугаар тогтоолын хавсралтын дагуу тооцоолон эдийн засгийн хэсгийн тооцоонд оруулав.

Хүснэгт 10. Нөхөн сэргээлтийн ажлын календарьчилсан төлөвлөгөө

№	Үзүүлэлтүүд	1 дэх жил
<i>Уулын ажлын хэмжээ</i>		
1	Хуулах шимт хөрсний хэмжээ, мян.м ³	1423,3
2	Шимт хөрсний овоолгын талбай, мян.м ²	5,95
3	Гадаад овоолго дахь үндсэн хөрсний хэмжээ, га	5.3
4	Дотоод овоолго дахь үндсэн хөрсний хэмжээ, га	5,3
5	Гадаад овоолгын талбай, га	5.3
6	Нийт уулын ажилд хамрагдах болон эвдрэлд орох талбай, га	29,4
7	Шимт хөрс хуулалтад ажиллах бульдозерын жилд ажиллах, цаг	32
<i>Нөхөн сэргээлтийн ажлын календарь төлөвлөгөө</i>		
8	Шимт хөрсөөр хучих, м ³	
9	Нөхөн сэргээх уурхайн тосгон болон зам талбай, га	
10	Нийт техникийн нөхөн сэргээлт хэмжээ, мян.м ³	
11	Нөхөн сэргээлтэнд ажиллах бульдозерын жилд ажиллах, цаг	
12	Нөхөн сэргээлтэнд ажиллах утгуурт ачигчийн жилд ажиллах, цаг	
13	Нөхөн сэргээлтэнд ажиллах автосамосвалын жилд туулах зам, км	
14	Нийт техникийн нөхөн сэргээх талбай, га 2025 онд	5
15	Нийт техникийн нөхөн сэргээх талбай, га 2026 онд	24,4

Хүснэгт 11. Эвдэрсэн газарт хийгдэх техникийн нөхөн сэргээлтийн ажлын зардлын тооцоо

№	Ажлын нэр	Хэмжих нэгж	Ашиглагдах техник	Ажлын хэмжээ, мян.м ³	Техникийн ээлжийн бүтээл	Гүйцэтгэх хугацаа, ээлжээр	Түлш зардал	Сэлбэг	Цалин	НДШ	Элэгдэл	Нийт зардал, сая төг
1	Ашиглагдсан орон зайг дүүргэх	мян.м ³	Автосамосвал, Эксковатор	15.50	1,938.00	1.81	2.1	0.1	0.5	0.02	0.14	2.86
2	Хоосон орон зай, ухшийн ирмэгийг хэвгийжүүлэх	мян.м ³	Бульдозер	20.77	2,774.80	1.72	1.60	0	0	0	-	1.60
3	Овоолгын хажууг хэвгийжүүлэн налуулах	мян.м ³	Бульдозер	35.03	1,938.00	22.08	4.8	0.5	2.5	0.13	0.21	8.14
4	Хэвгийжүүлсэн, нөхөн дүүргэсэн гадаргууг хэлбэржүүлэх, тэгшлэх, тэгшилсэн талбайг дэвсгэржүүлэх	мян.м ³	Бульдозер	10.57	2,774.80	0.93	1.45	0	0	0	0.00	1.45
5	Барилга байгууламжинд өртсөн газрыг тэгшлэх.	мян.м ³	Бульдозер	5.46	2,774.80	0.31	1.41	0.00	0	0	0.0	1.41
6	Шимт хөрсний овоолгоос шимт хөрс ухаж ачих, тээвэрлэн буулгаж, хучих ажил	мян.м ³	Бульдозер	3.24	2,774.80	4.36	1.45	0	0	0	0.03	1.48
	Техникийн нөхөн сэргээлтийн ажлын дүн	сая төг					12.81	0.6	3.0	0.15	0.38	16.94
Биологийн нөхөн сэргээлтийн зардал												
1	Ургамалжуулах ажлын зардал	га	1 га талбайн биологийн нөхөн сэргээлтийн зардлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ. Гэрээний үнийн дүн								0.6 га	3
	Нийт нөхөн сэргээлтийн ажлын дүн	сая төг	19.94									

9. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ

Төсөл хэрэгжих орчны оршин суугчдын газар эзэмших, ашиглах эрх хөндөгдөхгүй, одоогийн байгаа ахуй амьжиргаанд эдийн засгийн сөрөг нөлөө үзүүлэхгүй тул нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох зайлшгүй зардал тооцох шаардлагагүй болно.

10. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагааны явцад түүх соёлын өвийг хамгаалах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- Соёлын өвийг хамгаалах, хадгалах Монгол улсын хууль эрхзүйн орчныг дагаж мөрдөх
- Лицензтэй талбайгаас түүх соёлын дурсгалт олдворуудыг археологийн судалгаагаар илрүүлсэн боловч олборлолтын үед газар дээр ямар нэг таних тэмдэггүй дурсгал илэрч болзошгүй тул төсөл хэрэгжүүлэх явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрвэл төсөл хэрэгжүүлэгч ажлаа зогсоож энэ тухай сум, дүүргийн Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.
- Төслөөс шууд өртөж нөлөөлөгдөхөөргүй цэгүүдийг хамгаалах ажиллагаа, соёлын ба үнэт өв дурсгалтай газрыг хамгаалах төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулахдаа төв, орон нутгийн удирдах байгууллага, мэргэжилтнүүд, орон нутгийн олон нийтийн байгууллага, ШУА-ын Археологийн Хүрээлэн зэрэгтэй зөвлөлдөнө. Энэ төлөвлөгөө, хөтөлбөрийг төслийн бүтээн байгуулалт эхлэхээс өмнө төлөвлөж мөрдөнө.

Хүснэгт 12. Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө

Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өвүүд	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал /сая.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Уурхайн хөрс хуулалт болон олборлолтын үед Археологийн болон палеонтологийн ховор түүхийн дурсгалт олдворууд гарч ирж болзошгүй.	Хэрэв уурхайн үйл ажиллагааны үед Археологийн болон палеонтологийн ховор түүхийн дурсгалт олдворууд гарч ирэхэд төрийн холбогдох байгууллагуудад заавал мэдэгдэх ёстой.	Уурхайн ашиглах нийт газрын хэмжээнд	Тухайн үед нь шийдэх	Үйл ажиллагааны турш	Соёлын өвийг хамгаалах тухай хууль /2014 оны 05 сарын 15-ны өдрийн шинэчилсэн найруулга/,

11. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагааны туршид байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөгүй үйл ажиллагаа явуулах үүрэг хүлээж, мэргэжлийн боловсон хүчнээс бүрдсэн байгаль орчны асуудал хариуцсан байгаль орчны алба байгуулах ба төслөөс үзүүлж байгаа сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээ авч ажиллах боловч төслийн удирдлагын хэмжээнд онцгойлон анхаарч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд байна.

Хүснэгт 13. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал, сая төгрөг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10 ¹ болон БО-ны ерөнхий үнэлгээний шаардлагын дагуу 2 жил тутамд Байгаль орчны аудит хийлгэх	2 жил тутамд	Гэрээний үнийн дүнгээр	Эхний болон 3-р жил	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлэх (5 жилд 1 удаа).	Тусгай зөвшөөрөлтэй талбайд	Гэрээний үнийн дүнгээр	Хийгдсэн байгаа	Газрын тухай хуулийн 58.5
Орон нутгаас тавьсан санал хүсэлтийг харилцан тохиролцож шийдвэрлэж байх	Нийгмийн хариуцлагын хүрээнд	Тохиролцох	Төслийн хугацаанд	Нийгмийн хариуцлагын гэрээ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 14.1.3
Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх	Төслийн хугацаанд	Уурхайн дотоод төлөвлөлтөөр		Байгаль орчныг хамгаалах тухай хууль
Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОАЖЯ –нд хүргэж өгөх.	Жил бүрийн 12 сард	Уурхайн дотоод төлөвлөлтөөр		Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль Байгаль хамгаалахад орон нутгийн иргэдийн оролцоог идэвхжүүлэх, уулзалт зөвлөгөөг зохион байгуулах, тэдний санал зөвлөмжийг БОХТ-г хэрэгжүүлэх ажилд тусгах	Төслийн хугацаанд	Уурхайн дотоод төлөвлөлтөөр		Байгаль орчныг хамгаалах тухай хууль Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
Нийт		-		

12. ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ

Оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх. Баянголын дэнж хөндийн алтны ордыг ашиглах төсөл нь Төв аймгийн Заамар суманд хэрэгжих тул төслийн үйл ажиллагааны тайлан, мэдээг хамгийн их сонирхогч, оролцогч талууд нь эдгээр сумын удирдлагууд, ард иргэд, оршин суугчид болно. Тиймээс сонирхогчид болон оролцогч талуудад хүргэх мэдээллийг тэдгээрийн сонирхолд нийцсэн хэлбэрээр бэлтгэж, хэлэлцүүлэх, танилцуулах арга хэмжээг хийх шаардлагатай.

БОМТ-г орон нутагт танилцуулах, хэлэлцүүлэх ажлын зардал. Төслийн үйл ажиллагааны хүрээнд байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлсэн ажлын тайлан, мэдээг танилцуулж, хэлэлцүүлэх ажлыг жилд нэг удаа онлайнаар зохион байгуулах бөгөөд энэхүү ажлыг гүйцэтгэхэд 360.2 мян.төг-ийн зардал тооцогдож байна.

Хүснэгт 14. БОМТ-ний хэрэгжилтийн тайланг танилцуулах, хэлэлцүүлэх ажлын зардал

№	Хийх ажил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ, төг	Нийт үнэлгээ, мян.төг
1	Тайлан, илтгэл	удаа	1	0	0
2	Хурлын зар тараах	удаа	1	200,000	200
3	Хурал зохион байгуулах	удаа	1	1,000,000	1000
4	Хуралд оролцогсдын томилолт	хүн/өдөр	0	0	0
5	Шатахуун	л	0	0	0
6	Бусад зардал	хувь	8		100
Тайлан танилцуулах, хэлэлцүүлэх ажлын нийт зардал, мян.төг					1600

Хүснэгт 15. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Тайлан хүргүүлж тайлагнах	БОМТ-ний хэрэгжилтийн талаар	Жил бүрийн 11 сард	Цаашид анхаарах асуудал	БОНХЯ
Байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, Бүх шатны засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллага	Танилцуулж, тайлагнах	Тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийн талаар	Хагас жил тутам буюу 6, 11 сард	Цаашид анхаарах асуудал	Засаг даргын тамгын газар
Төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн сум, багийн иргэдийн хуралд	Хэлэлцүүлэх	БОМТ-ний хэрэгжилтийн талаар - Төслийн гүйцэтгэлийг хянаж, шалгах болон бусад мэдээллийг	Хагас жил тутам буюу 6, 11 сард	Цаашид анхаарах асуудал	Сум багийн иргэдийн хуралд
Байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, Бүх шатны засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллага	Тайлагнах	Үйл ажиллагааны явцад түүхт дурсгалт зүйлс болон соёлын олдвор олдсон тохиолдолд ямар арга хэмжээ авсан талаар	Тухай бүрд		Засаг даргын тамгын газарт
Төслийн ажилчид ба орон нутгийн иргэдэд	Тайлагнах	Төслийн ажилчид ба орон нутгийн иргэдээс гомдол, санал гарсан тохиолдолд цаг алдалгүй санал гомдлыг нь барагдуулах зорилгоор гомдол барагдуулах менежментийн төлөвлөгөөг тогтвортой хэрэгжүүлэх;	Тухай бүрд	Цаашид анхаарах асуудал	Иргэдэд

13. ҮР ДҮНГИЙН БҮРТГЭЛ ТАЙЛАНГИЙН ХҮСНЭГТ

Хяналт шинжилгээний явцад зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн бохирдол илрэх тохиолдолд мэргэжлийн болон хяналтын байгууллагуудад шуурхай мэдээлж, холбогдох арга хэмжээг өөрийн хөрөнгөөр авч хэрэгжүүлнэ.

Хяналт шинжилгээний бүртгэл тайлан эрх бүхий байгууллагаас гаргасан маягтаар гаргаж, мэдээ тайланг тогтоосон хугацаанд холбогдох байгууллагуудад хүргүүлнэ.